



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/342

Чингис хот

Олон улсын хэмжээний мастер
П.Энхманлайд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.3, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.1, 8.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын үндэсний пара хөнгөн атлетикийн холбооноос ирүүлсэн саналын дагуу Хэнтий аймгийн иргэн Олон улсын хэмжээний мастер П.Энхманлайн замын зардалд зориулж 1000000 (нэг сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх дэмжлэгт шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан санал хүсэлтийг шийдвэрлэх зардлаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ж.Ганбаатар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ЦИДЭРБАТ

231011744